



УЛААНБААТАР ОРОН
СУУЦЖУУЛАЛТ ХХК

АШИГЛАЛТЫН ШААРДЛАГА ХАНГАХГҮЙ ОРОН СУУЦНЫ ХЭЛТСИЙН

2025 ОНД ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСЛҮҮДИЙН ТАЙЛАН

/2025 оны 12дугаар сарын 25-ны өдрийн байдлаар/

УЛААНБААТАР ХОТ

2025 ОН

Нийслэлийн Засаг даргын 2025 оны 13 удаагийн захирамжаар нийт 80 байршлын барилгажуулах төсөл хэрэгжүүлэх эрх шилжиж ирсэн. Үүнээс 17 байршилд төсөл хэрэгжүүлэгч шалгарсан бөгөөд дахин төлөвлөлтийн үйл ажиллагаа шат дараатайгаар үргэлжлэн хэрэгжиж байна.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин барилгажуулах төслийн хүрээнд СХД-ийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах СТ-4 барилгыг буулган барилгын ажил эхэлж А блок 16 давхар, Б блок 16 давхар гадна өрлөгийн ажил явагдаж байгаа, доод давхраас эхлэн дотор өрөө хоорондын ханын өрлөгийн ажил хийгдэж байгаа, хаалга цонхнууд бүрэн суулгасан.



БГД-ийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах 32 дугаар байрны барилгын суурь болон зоорийн давхрын цутгалт хийгдэж дууссан мөн СБД-ийн 6 дугаар хорооны нутаг 22 дугаар байрны барилгын суурь болон зоорийн давхрын цутгалт хийгдэж дууссан.



Бусад 12 байршлын төсөл хэрэгжүүлэгч болон иргэд харилцан зөвшилцөх, тохиролцох, гэрээ байгуулах зэрэг ажлууд үе шаттайгаар хийгдэж байна. Төсөлд хамрагдсан байруудын сууц өмчлөгчдийн хяналтын хороо, үнэлгээний хорооны гишүүдийг томилуулж зөвлөгөө мэдээлэл зэргийг өгч хамтран ажиллаж байгаа бөгөөд иргэдтэй хоёрлосон болон гурвалсан уулзалтуудыг нийт 167 удаа хийсэн байна.




2025 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Монголын хүүхдийн ордонд "ХОТЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТ, АСУУДАЛ БА ШИЙДЭЛ" хэлэлцүүлэгийг дахин төлөвлөлтийн нөлөөлд өртөх өмчлөгчидийг оролцуулан зохион байгуулсан.




Нийт 20 байршилд сонгон шалгаруулалт зарласан бөгөөд үүнээс 15 аж ахуйн нэгж төсөл хэрэгжүүлэгчээр шалгарч үйл ажиллагаагаа эхлүүлээд байна. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж төсөлд хамрагдсан иргэдийн хооронд байгуулах 2 болон 3 талт гэрээний явц 80 хувьтай байна. Нийт 33 архитектур төлөвлөлтийн даалгавар, 7 барилгын загвар зураг батлагдаж, 2 барилга эхлүүлэх зөвшөөрөл авсан.



Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах төсөл хэрэгжүүлэгч 17 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулсан байна. Эдгээр шалгарсан компаниудын төлөвлөсөн орон сууц баригдаж дуусахад нийт 3000 гаран айлын орон сууц ашиглалтанд орно гэж төлөвлөж байгаа.



Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1060 дугаар захирамжаар Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт нийт 5 байршлын 31 ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг дахин төлөвлөх эрх шилжин ирсэн бөгөөд эдгээр байрны оршин суугч өмчлөгчидтэй хоёрлосон уулзалтыг зохион байгуулсан. Мөн архитектур төлөвлөлтийн даалгавар, газар эзэмших эрх шилжүүлэн авах тухай хүсэлтүүдийг холбогдох байгууллагуудад уламжилсан болно. Шинээр ирсэн байршлуудад хээрийн судалгаа хийж дэлгэрэнгүй танилцуулга бэлтгэн байршил тус бүр дээр газрын талбайн хэмжээг төсөөллөөр гарган 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах саналаа 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 01/376 дугаар албан бичгээр НГЗБА-нд хүргүүлсэн.



ТАНИЛЦСАН: АШХОСХ-ИЙН ДАРГА

Б.БАТ-УЧРАЛ

НЭГТГЭСЭН: АШХОСХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН

Ц.БОЛОРЦЭЦЭГ